



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/117/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
Улаанбаатар хот	тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
2023 он	Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
	Аудитын менежер: П.Чанцалдулам
	Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
	Аудитор: С.Алтанхуяг
	Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: "Интер аудит" ХХК
	Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхбаяр
	Цахим хаяг: info@interaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ТОГТВОРТОЙ
АВТО ЗАМ, ТЭЭВЭР ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ А.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2023.03.21 № 07/612
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайланд онд тус Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь үйл ажиллагаагаа эхэлсэнтэй холбогдуулан оффисын тоног төхөөрөмж, тавилга худалдан авах, шинээр барих гудамж замуудыг тодорхой болгож Дэлхийн банкнаас зөвшөөрөл авах, тээврийн ухаалаг системийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, системийн нарийвчилсан зураг төслийн зөвлөх үйлчилгээний ажлуудын даалгаврыг боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2021 оны 180 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц орон тоог 20 ажилтантай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 13 ажилтантай ажилласнаас тайлант хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээ нь цаг хугацаандаа хэрэгжээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,665,583,519.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,665,583,519.21
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	2,665,583,519.21
31210	Төгрөг	-	7,836,425.12
31211	Төрийн сангийн харилцах	-	7,836,425.12
31220	Гадаад валют	-	2,657,747,094.09
31221	Төрийн сангийн харилцах	-	2,657,747,094.09
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	150,766,040.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	150,766,040.81
392	Биет хөрөнгө	-	150,766,040.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	108,389,262.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,118,612.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	57,339,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,843,609.85)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	-	2,816,349,560.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	2,816,349,560.02
41	Богино хугацаат өр төлбөр	-	101,365.68
41300	Өглөг	-	101,365.68
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	62,794.26
41361	Байгууллагад төлөх өглөг	-	38,571.42
51	Засгийн газрын хувь оролцоо	-	2,816,248,194.34
512	Хуримтлагдсан үр дүн	-	2,816,248,194.34
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,816,248,194.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	2,816,349,560.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	-	3,121,050,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,121,050,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,121,050,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	3,121,050,000.00
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	3,121,050,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	572,872,830.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	572,872,830.63
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	-	3,862,822,934.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	-	435,457,190.47
210101	Цалингийн зардал	-	435,457,190.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	54,432,148.82
210201	Тэтгэврийн даатгал	-	54,432,148.82
2103	Байрны ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	46,720,800.00
210304	Байрны түрээсийн зардал	-	46,720,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	11,003,556.32
210401	Бичиг хэргийн зардал	-	9,569,156.32
210402	Тээвэр, шатахууны зардал	-	990,000.00
210403	Шуудан, холбооны зардал	-	444,000.00
2106	Эд хогшил, урсгал засвар зардал	-	4,698,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	4,698,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,700,178.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	-	5,700,178.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,962,221.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	-	14,962,221.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	2,548,177,169.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	268,071,024.97
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	268,071,024.97
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	268,071,024.97
6	НИЙТ ҮР ДҮН	-	2,816,248,194.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	3,121,050,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,121,050,000.00
120	Тусламжийн орлого	-	3,121,050,000.00
122004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	3,121,050,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	723,421,081.38
2	УРСГАЛ ЗАРДАЛ	-	723,421,081.38
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	723,421,081.38
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	-	435,394,396.21
210101	Үндсэн цалингийн зардал	-	435,394,396.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	54,393,577.40
210201	Тэтгэврийн даатгал	-	54,393,577.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	46,720,800.00
210304	Байрны түрээсийн	-	46,720,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	11,003,556.32
210401	Бичиг хэргийн зардал	-	9,569,156.32
210402	Тээвэр, шатахуун	-	990,000.00
210403	Шуудан холбооны зардал	-	444,400.00
2106	Эд хогшил урсгал засварын зардал	-	170,208,572.73
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	108,171,472.73
210602	Тавилга	-	57,339,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	4,698,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,700,178.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,700,178.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,397,628,918.62
4	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	267,954,600.59
14	Бусад эх үүсвэр	-	267,954,600.59
145001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	267,954,600.59
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	267,954,600.59
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,665,583,519.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,665,583,519.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,816,248,194.34	2,816,248,194.34
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,816,248,194.34	2,816,248,194.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	780,743,150.00	723,421,081.38	57,322,068.62	92.6
УРСГАЛ ЗАРДАЛ	780,743,150.00	723,421,081.38	57,322,068.62	92.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	780,743,150.00	723,421,081.38	57,322,068.62	92.6
Цалин,хөлс болон нэмэгдэл урамшуулал	464,166,000.00	435,394,396.21	28,771,603.79	93.8
Үндсэн цалин	464,166,000.00	435,394,396.21	28,771,603.79	93.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,020,750.00	54,393,577.40	3,627,172.60	93.7
Тэтгэврийн даатгал	58,020,750.00	54,393,577.40	3,627,172.60	93.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,710,000.00	46,720,800.00	1,989,200.00	95.9
Байрны түрээс	48,710,000.00	46,720,800.00	1,989,200.00	95.9
Хангамж, бараа материалын зардал	15,787,000.00	11,003,556.32	4,783,443.68	69.7
Бичиг хэрэг	8,500,000.00	9,569,156.32	(1,069,156.32)	112.5
Тээвэр, шатахуун	2,937,000.00	990,000.00	1,947,000	11.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,350,000.00	444,400.00	3,905,600.00	10.2
Томилолт, зочны зардал	179,359,000.00	170,208,572.73	8,982,900.00	94.9
Багаж, техник, хэрэгсэл	110,653,800.00	108,171,472.73	2,482,327.27	86.3
Тавилга	62,595,200.00	57,339,000.00	5,256,200.00	91.6
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,110,000.00	4,698,100.00	1,411,900.00	76.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,700,000.00	5,700,178.72	33,646,380.22	38.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,700,000.00	5,700,178.72	8,999,821.28	38.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,121,050,000.00	(3,121,050,000.00)	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	3,121,050,000.00	(3,121,050,000.00)	-
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	3,121,050,000.00	(3,121,050,000.00)	-
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,665,583,519.21	2,665,583,519.21	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулгын зөрүү		267,954,600.59		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСДЫН ТОО				
Удирдах ажилтан	20	13	8	65.0
Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	17	10	7	58.0

Гурав. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 101.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТХН-ийн нэг ажилтны 2022 оны 10, 11 дүгээр сарын цалинг буруу тооцсоноос 74.0 мянган төгрөгийн НДШ, 27.3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, Татвар, Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй байна.	1	101.3			1	101.3			1	101.3	1	101.3
Дүн	1	101.3			1	101.3			1	101.3	1	101.3

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 1 зөвлөмж өгсөн.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим системд нийт 171 мэдээлэл оруулахаас 154,197.2 төгрөгийн 97 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээлэл оруулаагүй байна.	1	154,197.2						1	154,197.2
Дүн	1	154,197.2						1	154,197.2

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.